

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46.1 дүгээр зүйл, “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК нь 2024 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрэн зогссон бөгөөд банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдэд “2024 оны ногдол ашиг хуваарилахгүй тухай” мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Чанцалдулам-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.НАРАНЦАЦРАЛТ